



БАТЛАВ: ӨНДӨРХААН ИЛЧ ХХК

ЗАХИРАЛ

Б.БУЛГАНТОГТОХ

**ДУЛААН ХАНГАМЖИЙН ТӨВЛӨРСӨН СИСТЕМД ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОЛБОХ
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 7**

2023 оны 08-р сарын 12

10. **Барилга объектын нэр хаяг** : “Эрүүл мэндийн төв”-ийн барилгын өргөтгөл
11. **Барилга объектын байршил**: Хэнтийн аймаг Цэнхэрмандал сум
 - А.Халаалт 0.043 Гкал/цаг
 - Б.Хэрэгцээний халуун ус 0.00 Гкал/цаг
 - В.Салхилуулга 0.00 Гкал/цаг

Нийт: 0.043 Гкал/цаг
12. **Дулааны холболтын цэг**: Хуучин эмнэлгийн барилгын дэргэдэх “ӨНДӨРХААН ИЛЧ” ХХК компанийн эзэмшил дулааны 6-р худагаас холбогдоно. Төлөвлөж буй барилгын дэргэд 2*2*1,5 м харьцаатай үзлэгийн худаг гаргах ба худагт ф76 хэмжээтэй дулааны хоолойноос барилгын ачаалалд тохируулан огтолгоо авна.
13. **Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага**:
 - 13.1 “Эрчим хүчний тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 1.3 дахь заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх. Шугамын хамгаалалтын зурваст тохжилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.
 - 13.2 Архитектур төлөвлөтийн даалгавар, эскиз зургийг үндэслэн зураг төслийг хянана.
14. **Дор дурдсан техникийн даалгаврын дагуу зураг төслийг хийх**.
 - 14.1 Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаанд багтаан дулаан хангамжинд холбогдох.
 - 14.2 Гадна дулааны угсралтыг газарт сувагтай болон суваггүй системээр холбож болно. Суваггүй систем сонгох бол урьдчилсан дулаалгатай ган хоолой сонгох,. Компенсаторыг нормын дагуу төлөвлөх ба сильпон компенсатор дээр заавал худаг гаргах шаардлагатай
15. **Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага**:

Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцөлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
16. **Архивт бүрдүүлэх материал**:

Барилга хөгжлийн төвийн дүгнэлттэй гадна дулааны шугамын зурагийг автокад файлаар болон хэвэлмэлээр сумын архивт хадгалуулах.
17. **Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа**:

Энэхүү техникийн нөхцөл олгосоноос хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
18. **Техникийн нөхцөлийг хүчингүй болгох**:
 - 18.1 Энэхүү техникийн нөхцөлийн заалтыг биелүүлээгүй.
 - 18.2 Техникийн нөхцлийн хугацаа дууссан.
 - 18.3 Техникийн нөхцлийн ачаалал 10 аас дээш хувиар өөрчлөгдсөн

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



/Б.БУЛГАНТОГТОХ /